



ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 19 өдөр

Дугаар

#102

Мөрөн сум

Засаг даргын Тамгын газрын Өмч хамгаалах
байнгын зөвлөлийг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Аймгийн ИТХурлын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан “ Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам” ын 2.1.1 дахь заалтуудын тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус ажлын хэсэг нь Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг мөрдлөг болгон Сумын засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийн бүртгэл, хувийн хэрэг хөтлөх, улсын бүртгэлд бүртгүүлэх, хөрөнгийн тооллого хийх, санхүүгийн болон статистикийн мэдээ, тайланг гаргах, холбогдох журмын дагуу тайлагнах ажлыг хариуцсугай.

2.Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: -Санхүү албаны дарга бөгөөд төсвийн ерөнхий нягтлан бодогч

Нарийн бичгийн

дарга: - Төрийн сангийн мэргэжилтэн

Гишүүд :

- ИТХ, ЗДТГ хариуцсан ня-бо

- Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн


- Хууль, эрх зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

-Байгаль орчны хяналтын улсын байцаагч

3.Өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөө гарган батлуулж ажиллахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Төрийн сангийн мэргэжилтэн)-д, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Зөвлөлийн дарга (Санхүү албаны дарга бөгөөд төсвийн ерөнхий нягтлан бодогч)-д тус тус даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Тамгын газрын даргын 2025.06.09-ний өдрийн А/24 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н.НАМЖИЛНОРОВ